

“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН 2016 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2016 оны 07 сарын 25-ны өдөр

Улаанбаатархот

Тус компани өнгөрсөн онд олсон амжилтаа бататгаж, тайлант хугацаанд компанийн орлогыг нэмэгдүүлэх, шуудангийн үйлчилгээг өргөтгөж, хүн амд ойртуулах зорилгоор шинээр хэрэгжүүлж эхэлсэн ажлуудыг улам сайжруулах, шинэ нэр төрлийн үйлчилгээг нэмэгдүүлэх хүрээнд хүргэлтийн үйлчилгээг өргөжүүлэх, цахим технологийн бизнесийг нэвтрүүлэн хөгжүүлэх, онлайн худалдааны хүргэлтийн үйлчилгээг нэвтрүүлэх зэрэг зорилтуудыг дэвшүүлэн дараах чиглэлээр ажиллалаа.

Монгол шуудан ХК эхний хагас жилийн байдлаар 5599.9 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөтэй ажиллаж, 5125.8 сая төгрөгийн орлого оруулан 91.5 хувийн биелэлттэй ажилласан нь ч өнгөрсөн оны мөн үеийнхээс 2.6 хувиар өссөн дүнтэй байна. Түүнчлэн компанийн үйлдвэрлэлийн зардлын төлөвлөгөө 4896,6 сая байснаас 4837.34 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллаж 1,2 хувиар зардлаа хэмнэн ажилласан байна. Татварын дараах ашиг 193.2 сая төгрөг байна.

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын ажлын хүрээнд

2015 оны УИХ-ын 70-р тогтоол, ЗГ-ын 330-р тогтоол, Төрийн өмчийн хорооны 594-р тогтоолын дагуу Монгол шуудан ТӨХК-ийн 66 хувийг төрд үлдээж, 34 хувийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан хувьчлах болсонтой холбогдуулан хувьчлал явагдаж компанийн төрийн өмчит статус хувьцаат компани болон өөрчлөгдсөн. Үүнтэй холбоотой компанийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл, тамга тэмдэг, хэвлэмэл хуудас зэргийг шинэчиллээ.

Өнгөрсөн оны тайлан баланс, үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж газар, салбар, нэгжүүдийн зорилтыг нь нэг бүрчлэн тодорхойлж төлөвлөгөөжүүлэн ажиллаж байна. Энэ оны зорилтыг хэрэгжүүлэх үүднээснийт 170 асуудал тусгаж төлөвлөснөөс эхний хагас жилд 45,8 хувийн гүйцэтгэлтэй ажиллав.

2016 оны эхний хагас жилийн байдлаар компанийн хэмжээнд 1196 ширхэг албан бичиг ирсэнээс хариутай 54 ширхэг, хариугүй 1142 ширхэг ирж 100хувийн гүйцэтгэлтэй хариутай бичгийг хүргүүлэв. Гүйцэтгэх захирлын А тушаал 38 ширхэг, Б тушаал 107 ширхэг гарлаа.

Ажилтан, албан хаагчид болон бусад албан байгууллага, хувь хүмүүсээс ирсэн 65 ширхэг өргөдөл, гомдол ирсэнээс 81,5 хувийг нь шийдвэрлэж хаасан.

Компанитай холбоотой хууль эрх зүйн чиглэлийн бүх асуудлыг цаг тухай бүрд нь шийдвэрлэн ажиллаж байна.

Компанийн үйл ажиллагаа, авилга, ашиг сонирхлын зөрчлийн талаар санал, гомдол, хүсэлтийг хүлээн авах цэсийг шинэчилсэн цахим хуудсанд байршуулснаар асуудлыг зохих шатны мэрэгжилтнээс тодруулан шийдвэрлэх боломжтой болгосон.

Төлөвлөгөөнд тусгагдсанаар компанийн аймгийн ШҮГ-ын дарга нарын сарын үндсэн цалинг 2016 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж 100 мянган төгрөгөөр нэмэгдүүллээ.

Хүний нөөц, нийгмийн асуудал шийдвэрлэх чиглэлээр:

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, компанийн Хөдөлмөрийн дотоод журам, захиргаа ҮЭХ-ны хооронд байгуулсан хамтын гэрээг өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж, ажилтны ар гэрт нь хагацал тохиолдсон 2 хүнд 600 мянган төгрөгийн, нас барсан 4 өндөр настанд 400 мянган төгрөгийн, ойр дотных нь хүн нас барсан 10 ажилтанд 1,900 мянган төгрөгийн тэтгэмж, хүндээр өвдсөн 2 ажилтанд 400,0 мянган төгрөгийн, гэнэт гамшиг осол тохиолдсон 1 хүнд 1 сая төгрөгийн буцалтгүй тусламж, тэтгэмж үзүүллээ.

Билгийн улирлын хаврын тэргүүн сарын шинийг нэгэн, цагаан сарын баярыг тохиолдуулан ахмад настнууд, ажиллаж байгаа болон өндөр насны тэтгэвэрт гарсан

“Хүндэт шууданч” нарт 4.6 сая төгрөгийн нэмэгдэл тэтгэмжийг олгосноос гадна тэднийг хүлээн авахад 6.1 сая төгрөг зарцуулсан байна.

Мэдээлэл харилцаа холбооны салбарын 95 жилийн ойг тохиолдуулан, Алтан гадас одонгоор Хөвсгөл аймгийн ШҮГ-ын хүргэгч-жолооч Б.Дашбалжир, Хөдөлмөрийн хүндэт медалиар Захиргаа удирдлагын хэлтсийн дарга Б.Уянга, 34-р салбарын касс-ялгагч Т.Батсүх, 20-р салбарын касс-ялгагч Л.Ариунаа, Сүхбаатар аймгийн ШҮГ-ын нягтлан бодогч З.Цэрэнчимэд, өндөр настан Д.Нэргүй, Сэлэнгэ аймгийн ШҮГ-ын касс-ялгагч Д.Саранцэцэг, Дархан-Уул аймгийн ШҮГ-ын нягтлан бодогч С.Дунгаамаа нарыг, Монголын залуучуудын холбооны цол тэмдэгээр 6 хүн, МХХ салбарын шагналаар 31 хүн, байгууллагын шагналаар 71 хүнийг тус тус шагналаа.

Ажиллагдсын эрүүл мэнд, бие бялдрыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх орчин нөхцлөөр хангах зорилгоор бялдаржуулах танхимыг стандартын дагуу ажиллуулж, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх, ажлын байрны нөхцлөөс хамааран зарим ажилчдад нормын сүү, сүүн бүтээгдэхүүнийг тогмол олгуулж байна.

Сургалтын чиглэлээр: Энэ жилээс нийт ажилтнуудын сургалтын хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр сургалтыг ганцаарчилсан, хэсэгчилсэн, бүх нийтийн хэлбэрээр онлайн, танхим, үйлдвэрлэл, байгалийн үзэсгэлэнт газруудад чанарын өндөр түвшинд зохион байгуулахаар төлөвлөн эхнээс нь хэрэгжүүлэн ажиллаж байна. Албан тушаал ахих хүсэлтэй хүргэгч нарт ахих албан тушаалын мэдвэл зохих мэдлэг олгох зорилгоор ахисан түвшний сургалт зохион байгуулж 21 хүргэгчийг хамруулан хангалттай үнэлгээ үзүүлсэн 10 хүргэгчийг шалгаруулан эхнээс нь кассын албан тушаалд томилон ажиллуулж байна.

Шуудангийн үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтран Амьдрах ухаан, Гоо зүйн сургалт зохион байгууллаа.

Цаашид Гүйцэтгэх захирлын батласан сургалтын төлөвлөгөөний дагуу ажилтнуудыг чадавхижуулах сургалтуудыг зохион байгуулж ажиллаж байна.

Ажлын цаг ашиглалтын чиглэлээр: Цаг бүртгэлийн системийг нэвтрүүлэн, ажлын цаг ашиглалтанд тогтмол хяналт тавин ажилласнаар ажлын цагийн хоцролт компанийн хэмжээнд өнгөрсөн оны мөн үеийнхээс 77,6 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Гүйцэтгэх захирлын А/07 тоот тушаалаар “Цагийн бүртгэл, ажлын цаг ашиглалтанд хяналт тавих журам”-ыг шинэчлэн батлаж 2016 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдлөг болгон ажилласнаар ажилтнуудын шалтгаангүй хоцролт, ажлын дундуур хийдүүлэлт эрс багассан.

Гадаад харилцаа хамтын ажиллагааны чиглэлээр: Энэтхэг улсын Калкутта хотод болсон АНДБШХ-ны ээлжит бусчуулганд оролцсон. Хонг-Конгийн “EAST SOLUTION” компанийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзан Хятад-Монгол-Орос гурван улсын эдийн засгийн коридор байгуулах төслийн хүрээнд хамтран ажиллах гэрээ байгуулах, ОХУ-ын Хиагт хотод ажиллан транзит шуудангийн тээвэрлэлтийн талаар хамтран ажиллах уулзалт хийгдлээ. Мөн БНХАУ-ын Чунчин хотод зохион байгуулагдсан Шуудангийн байгууллагуудын дээд түвшний чуулга уулзалтанд оролцлоо.

Дэлхийн Шуудан Холбооны ОУ-ын товчооноос зохион байгуулж буй Ази-Номхон далайн бүсийн улсуудад зориулсан 2016 оны тэтгэлэгт сургалтанд байгууллагаас 2 ажилтанг хамрууллаа.

Хоёр. Маркетинг, төлөвлөлтийн ажлын хүрээнд

Компанийн 2015 оны зорилтот түвшингийн гүйцэтгэлийг гарган, 2016 оны зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хийж, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар батлуулан харъяа газар, салбар, нэгжид орлого, зардал, солилцооны төлөвлөгөөг хуваарилан ажиллалаа.

Монгол Шуудан ХК-ийн худалдан авалтын төлөвлөгөөг олон нийтэд зарлан Шилэн дансны хуулийг мөрдөж ажиллах чиг үүргийг хэрэгжүүлж, Засгийн газар, Сангийн яамны shilendans.gov.mn, pmmis.mof.gov.mn сайтуудад төлөвлөгөөг байршуулах, худалдан авалтыг зарлах, хөтлөх ажлыг гүйцэтгэж байна.

Шинээр хэрэгжүүлж буй ажлыг улам сайжруулах чиглэлээр:

Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд шуудангийн үйлчилгээг нэвтрүүлэх ажлын хүрээнд тус төвд шуудангийн үйлчилгээг эхлүүлэх, шуудангийн салбар байгуулах чиглэлээр уулзалт зохион байгуулж, гэрээний төсөл болон шуудангийн технологийг боловсруулж, ажлыг эхлүүлээ.

Хүргэлтийн үйлчилгээг өргөжүүлэх ажлын чиглэлээр:

Замын хөдөлгөөний торгуулийн хуудсыг орон нутагт хүргэх ажлыг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс Булган аймгийн ШҮГ-т хэрэгжүүлж эхэлсэн ба Хөвсгөл аймгийн замын цагдаагийн тасагтай хамтран ажиллах гэрээ байгуулж, сургалт зохион байгуулан Хөвсгөл аймгийн ШҮГ-т нэвтрүүлэхээр бэлтгэл ажил хангагдаад байна. Цаашид энэ үйлчилгээг бүх аймгуудад хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Шинээр нэвтрүүлсэн хүргэлтийн үйлчилгээгээр дараах орлогыг төвлөрүүллээ.

/мянган.төг/

№	Хүргэлтийн үйлчилгээ	Тоо ширхэг	Мөнгөн дүн
1	Торгуулийн хуудас	191 995	490097,0
2	Гадаад паспорт	4 166	14581,0
3	Хуулийн этгээдийн гэрчилгээ	171	427,5
4	Тусгай шуудан	986	6133,4

Шуудангийн үндсэн үйлчилгээгээр дараах орлогыг төвлөрүүллээ.

/мянган.төг/

№	Үндсэн үйлчилгээ	Орлого	
		Төлөвлөсөн	Гүйцэтгэл
1	Бичиг захидал, боодол	786156,9	777334,5
2	Илгээлт буухиа шуудан	1053939,2	1083831,8
3	Шуудангийн хайрцаг	82570,0	73623,9
4	Хүргэлтийн үйлчилгээ	475803,7	557988,0
5	Хэвлэлийн шимтгэл	294253,0	193193,8
6	Марк, үнэт цаас	423778,5	428644,3
7	Улс хооронын тооцоо	1200000,0	1230913,3
8	Бусад	1283489,5	780315,6

Директ шуудангаас эхний хагас жилд нийт 16 359 224 төгрөгийн орлого, хэвлэл захиалгаар 47987 хэвлэл 662268591 төгрөг, нэмэлтээр 4499 хэвлэл 26797000 төгрөг, ном 2905 ширхэг 20766210, ном нэмэлтээр 324 ширхэг 2528120 төгрөгийн ном, хэвлэл захиалагдав.

Хэвлэх болон дугтуйны үйлдвэрийн гол бүтээгдэхүүн болох 4 төрлийн дугтуй 163,650 ширхэг, мөнгөний дугтуй 230,000 ширхэг, анхан шатны маягт, бүртгэлийн дэвтэр 189,725 ширхэг, RD код 162,000 ширхэгийг үйлдвэрлэж аймаг, салбаруудын худалдаанд болон дотоодын хэрэгцээнд нийлүүлсэн.

МҮОНРТ-тэй гэрээ байгуулж “Ээждээ бичих захидал” нэвтрүүлгийн захидал хүргэх ажлыг зохион байгуулав.

Эх үрсийн баярыг тохиолдуулан нийгмийн өмнө хүлээх хариуцлагаа ухамсарлаж ШШБЕГ-ын хорих ангиудад хоригдон ял эдлэж байгаа 5000 хүмүүжигчдийг ар гэртээ үнэгүй захидал илгээх боломж олгож захидал бичлүүлж ар гэрт нь хүргэх ажлыг амжилттай зохион байгуулж талархал хүлээлээ.

МИАТ компанитай удаа дараа уулзалт хийсний үр дүнд 2 дахин нэмэгдсэн гадаад шуудангийн тээврийн тарифийг бууруулж ажиллах гэрээ байгууллаа. “Монгол гэр, үндэсний хувцас” сэдэвт марк, “МТШХХ-ны салбарын 95 жилийн ойн марк, “АСЕМ-11” сэдэвт 2 блок марк тус тус гаргаж анхны өдрийн нээлтүүдийг хийлээ.

Цахим технологийн бизнесийг нэвтрүүлэн хөгжүүлэх чиглэлээр:

- Цахим сонин хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулан програмын хөгжүүлэлт болон сайтад байрших сонин сэтгүүлүүдтэй уулзалт зохион байгуулсан ба төлбөр тооцоо гүйцэтгэх банкуудтай гэрээ байгуулж бэлтгэл ажлыг ханган ажиллаа.
- ГТЕГ-тай хамтран ажиллах гэрээ байгуулж шүүхийн мэдэгдэх хуудсыг гибрид шуудангаар хүргэх ажлын програм хангамжийн болоод технологийн процессийг тодорхойллоо.
- Мобикомын шинэ хэрэглэгчдэд хүргэх захидлыг гибрид хэлбэрээр хүргэх ажлыг эхлүүлж 6-р сард 717 гибрид шуудан хүргэгдсэн байна.

Гурав. Шуудангийн сүлжээг хөгжүүлэх, технологийн тасралтгүй хэвийн ажиллагааг хангах ажлын хүрээнд

Шуудангийн үйлчилгээний чанар, соёлыг дээшлүүлэх, технологийн шат дамжлагыг техник хэрэгслээр хангаж будлиан саатлыг арилгах, шинэ үйлчилгээ нэвтрүүлэх, солилцооны бүртгэл тооцоог боловсронгуй болгох, улс хоорондын болон дотоод шуудангийн чиглэл, маршрутыг оновчтой сонгох, хэрэглэгчдээс ирсэн санал гомдлыг барагдуулж түүний мөрөөр зохих арга хэмжээг шуурхай авч ажиллах, ажлын сахилга бат, мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллаж байна.

Орлого, солилцоог нэмэгдүүлэх зорилгоор өнгөрсөн онд нэвтрүүлсэн гибрид шуудангийн ялган боловсруулалт, хүргэлтэнд анхаарч холын хүргэлттэй салбарт автомашин гарган зохион байгуулж байна. Шүүхийн Ерөнхий Зөвлөлтэй хамтран явуулж байгаа гибрид шуудангаар энэ хагас жилд 23620 ширхэг албан бичиг хүргэж гардуулав. 1 дүгээр улирлаас Налайх дүүргийн шүүхээс гибрид хүргүүлж эхлээд байна.

Улс орнуудад илгээх бичиг захидал болон боодлыг дамжуулах транзит улсуудын групп орнуудын судалгааг хийж бичиг захидал, боодолд илгээх маршрут хийн батлан, мөрдөж ажиллаж байна.

Шуудангийн сүлжээг хөгжүүлэх, сүлжээний тасралтгүй хэвийн ажиллагааг хангах үйл ажиллагааны хүрээнд 2016 оны эхний хагас жилийг 2015 оны эхний хагас жилтэй харьцуулсан харьцуулалт.

1. Бичиг захидлын солилцоо:

№	Үзүүлэлт	2015 он	2016 он	Зөрүү
1	Орох (ш)	713596	739538	25942

2. Илгээлт, буухиа шуудангийн солилцоо:

№	Төрөл	Гарах				Орох			
		2015 он		2016 он		2015 он		2016 он	
		Гадаад	Дотоод	Гадаад	Дотоод	Гадаад	Дотоод	Гадаад	Дотоод
1	Илгээлт	2980	6619	2763	7369	10738	8379	10280	8356
2	Буухиа	4715	9503	5332	11833	17254	13226	16130	19652
	Нийт	7695	16122	8095	19202	27992	21605	26410	28008

3. Ялган боловсруулсан хэвлэл:

№	Үзүүлэлт	2015 он	2016 он	Зөрүү
1	Солилцооны тоо (ш)	3871600	3328939	-542661
2	Жингийн орлого(₮)	197487400	158326400	-39161000
3	Хугацаа хожимдуулсан хэвлэлээс орлого (₮)	3700000	1597900	-2102100

4. Гадаад солилцоо:

№	Чиглэл	Солилцоо	2015 он		2016 он	
			Богцын тоо	Жин	Богцын тоо	Жин
1	Агаар	орох	18772	182345,66	19913	149934,3
		гарах	3266	26982,06	3732	24853,7
2	Газар	орох	382	4045,2	13863	59870.9
		гарах	104	826,5	25913	141599.8

Мэдээллийн системийн аюулгүй, найдвартай ажиллагааг хангах чиглэлээр:

POSTNETv3 системд шинээр нэмэгдэж буй Гар утасны гардуулалтын програм, Торгуулийн хуудас, НӨАТ-ын баримт хэвлэх модулиудыг шинээр үйл ажиллагаанд нэвтрүүлэн хяналт тавин ажиллаж байна. IPS систем дээр логистикийн үйл ажиллагаанд зориулан сервер компьютерийг бэлдэн ашиглалтанд оруулж сүлжээг холбон үйл ажиллагаанд оруулан ажиллаа. Масс мессежний програм хангамжийг үйл ажиллагаанд нэвтрүүлэв.

POSTNETv3 систем дээр хэрэглэгчид мессежээр тухайн илгээмжийн төлвийн мэдээлэл дамжуулах програмыг нэвтрүүлэв. Хүргэгч нарыг гар утсаар хангасантай холбогдуулан 85 утсыг GPS-ийн системд холбон байнгын хяналттай болгов. Rio.mn худалдааны цахим хуудастай хамтран ажиллах гэрээний дагуу POSTNETv3 систем нэмэлт серверийг үйл ажиллагаанд нэвтрүүллээ.

Дөрөв. Дүгнэлт, зорилт

2016 оны эхний хагас жилд хийж гүйцэтгэхээртөлөвлөсөн ажлаа 45.8 хувийн биелэлттэйгээр хэрэгжүүлсэн ба үлдсэн хугацаанд төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэн, төлөвлөгөөний биелэлтийг шахан ажиллахаар зорьж байна.

“Монгол шуудан” ТӨХК нь хувьчлагдан, хувьцааны 34 хувийг иргэд олон нийтэд нээлттэй санал болгон амжилттай арилжиж, хувьцаат компани болгон өөрчилсөнтэй холбогдуулан аймаг, нийслэлийн хэмжээнд ашиглаж буй хэвлэмэл хуудас, тамга тэмдэг, гэрчилгээг өөрчлөн шинэчилсэн.

Шинээр баригдаж буй орон сууцны хорооллыг нэг стандартын шуудангийн хайрцагтай байлгах зорилгоор Барилга орон сууцны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд “Шинээр баригдаж байгаа орон сууцнуудад өрхийн тоогоор шуудангийн хайрцаг байршуулах” гэсэн заалтыг оруулах санал дэвшүүлсэн.

Цахим технологи эрчимтэй хөгжиж байгаатай холбогдуулан хэвлэлийг цахимаар захиалан унших боломжийг нээх бэлтгэл ажлыг ханган ажиллалаа. Онлайн худалдааны хүргэлтийн бизнесийг эхлүүлж, цаашид дотоодын онлайн худалдааны сайтуудтай хамтран ажиллахаар хэлэлцээр хийн ажиллаж байна.

Гибрид шуудангийн үйлчилгээгээр Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс орон нутагт албан бичгээ хүргүүлэх болсон нь шуудангийн үйлчилгээний найдвартай байдлыг үйлчлүүлэгч нарт мэдрүүлсэн томоохон ажил болсон. Иймд цаашид татварын байгууллагын өрийн бичиг, үүрэн телефоны операторуудын авлагын захиаг хүргэх зэргээр олон байгууллагуудын үр ашиггүй бичиг хэргийн зардлыг бууруулах, цаг хугацаа хэмнэх, ашиг орлогыг нэмэгдүүлэх нийгэм, эдийн засгийн өндөр үр өгөөжтэй өргөжин тэлэх бүрэн боломжтойгоор төлөвлөгдөн ажиллаж байна.